

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ТЗУХ-ИЙН ТҮНТ-ИЙН 2022 ОНЫ 04 ДҮГЭЭР
САРЫН 22-28-НЫ ӨДРҮҮДЭД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2022 оны 04 дүгээр сарын 28

Хэрлэн сум

Өргөдөл гомдол санал хүсэлтийн мэдээлэл: 70563111 утсанд 5 өргөдөл гомдол санал хүсэлт ирж шийдвэрлэж хариу өгсөн 2, шийдвэрлэлтийн шатандаа 3 байна. Өргөдлийг утгаар нь авч үзвэл: Эмнэлэгт үзүүлж групп тогтоолгох гэхэд 2 багийн хооронд явуулаад байна, группд яаралтай оруулж өгнө үү, К-30-р байр орцны гэрэлгүй байна, гэрэлтүүлгийг хэвийн ажиллуулж өгнө үү, Дадал суманд 18 нас хүрээгүй хүүхдийн газрыг эцэг эхэд нь олгохгүй байна гэсэн санал хүсэлт ирсэн. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөлд үзлэгт хамруулж, үйлчилгээг хэвийн авч гомдолгүй болсон талаар хариуг өгсөн. Бусад өргөдлүүд шийдвэрлэлтийн шатандаа явагдаж байна. Засгийн газрын 1111 төвд шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 2 өргөдөл, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй 2 өргөдлийг НБХэлтээс хариуг шийдвэрлүүлж иргэнд хариу мэдэгдсэн.

Төрийн үйлчилгээний талаар.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нийт 602 иргэн үйлчлүүлснээс утсаар 70, цахимаар 8, биечлэн 524 иргэн ирж үйлчлүүлснээс: Улсын бүртгэлээр 173, Нийгмийн даатгалаар 55, Хөдөлмөр халамжийн үйлчилгээгээр 65, Газрын харилцаагаар 107, Хууль зүйн зөвлөгөөгөөр 3, Архивын үйлчилгээгээр 9 хадгаламжийн нэгж 931 хуудас баримтад 4000 хуудас тодорхойлон бичилт хийж 1 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн. Нотариатаар 35, E-mongolia сурталчилах цэгээр 14, E-Khutuch.mn булангаар 7, Төрийн банкаар 55, Брокер диллерээр 9,

Үнэлгээний төхөөрөмжинд маш сайн 483, сайн 39, дунд 2 үнэлгээ өгөгдсөн байна.

Өөртөө үйлчлэх танхимаар 193 иргэн үйлчлүүлсэн байна.